МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 12 сарын 09 өдөр Дугаар А/437 Мөрөн сум

Дипломат, гадаад албан паспорт
олгох хүсэлт уламжлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Засгийн газрын 2020 оны 190 дүгээр тогтоолоор батлагдсан "Монгол Улсын дипломат, албан гадаад паспорт олгох, эзэмших, хадгалах журам" -ын 2.2.2, 2.2.5, 3.7.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Боловсрол Шинжлэх Ухааны Яам, Бүгд Найрамдах Солонгос Улсын Дэжон хотын боловсролын газар хоорондын 2021 оны 04 дүгээр сард байгуулсан "Боловсролын солилцоо хамтын ажиллагааны тухай" харилцан ойлголцлын санамж бичгийн хүрээнд Монгол Улсад сургалтын үйл ажиллагаа явуулж буй байгууллагын удирдлагыг мэргэжил дээшлүүлэх сургалт, туршлага солилцох ажлын хүрээнд Монголын багш нарын боловсролын мэдээллийн технологийн сургалт 2023 оны 01 дүгээр сард болохоор төлөвлөж байгаа бөгөөд аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга Ц.Ганзориг оролцох болсон тул албан паспорт олгуулах хүсэлтийг Гадаад харилцааны яаманд уламжилсугай.

2. Гадаад улсад албан томилолтоор ажилласан тухай бүртээ холбогдох мэдээллийг илтгэх хуудсаар аймгийн Засаг даргад танилцуулж ажиллахыг Боловсролын газрын дарга (Ц.Ганзориг)-т үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Б.Мөнгөн-Эрдэнэ)-д даалгасугай.

ДАРГА Ш.ИДЭРБАЯСГАЛАН

Захирамж-2022

6710011083